



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/408

Чингис хот

Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 29.1.6-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2020 оны А/211 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг бог малын бүх төлийг хамруулан 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлын хэсэгт Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон ажиллуулж, технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж, ажлын явц, чанар, гүйцэтгэлд хяналт тавих, дархлаажуулалтын дүнг танилцуулах, санхүүжилтийн баримт материалыг холбогдох яаманд хүргүүлэх ажлыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010482